



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2018 оны 7 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26%-иар буюу 1,525 сая ам.доллараар өсч 7,382 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 17%-иар буюу 596 сая ам.доллараар, импорт 40%-иар буюу 929 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 333 сая ам.доллараар буурч 851 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 7 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	4,374	5,857	7,382	1,483	34%	1,525	26%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	2,541	3,520	4,117	979	39%	596	17%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	1,833	2,337	3,266	504	28%	929	40%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	709	1,184	851	475	67%	(333)	-28%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2018 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 232 сая ам.доллараар буурч 1,036 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 67% буюу 4,920 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 13% буюу 994 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 41%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 27%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 24%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 3%-иар буурч 1.969-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад тайлант сард экспортын үнийн өөрчлөлт бага байсан, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөлөв.

* Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

Экспорт 2018 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 17%-иар буюу 596 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 15 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.8 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		2,184	86%	3,096	88%		3,636	88%		912	42%	36%	540	17%	15.3%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	945	1,041	41%	853	889	25%	848	1,176	29%	(152)	-15%	-6%	287	32%	8%
1.2. Чулуун нүүрс	10,997	337	13%	20,853	1,404	40%	20,549	1,611	39%	1,067	317%	42%	207	15%	6%
1.3. Боловсруулаагүй нефть	4,772	186	7%	4,349	211	6%	3,851	251	6%	24	13%	1%	40	19%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,476	132	5%	3,132	175	5%	3,961	181	4%	43	33%	2%	6	4%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	8,511	341	13%	5,404	218	6%	3,432	144	4%	(124)	-36%	-5%	(73)	-34%	-2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	77	83	3%	70	103	3%	71	124	3%	21	25%	1%	20	20%	1%
1.7. Жонош, лейцит, нефелинт	137	32	1%	165	41	1%	240	79	2%	9	29%	0%	38	94%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	14	1%	4	20	1%	3	27	1%	6	39%	0%	7	34%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	5	0%	0	2	0%	0	3	0%	(2)	-49%	0%	1	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	29	12	0%	0	0	0%	0	0	0%	(12)	-96%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	51	1	0%	224	32	1%	283	38	1%	31	20x	1%	6	19%	0%
2. Мал аж, ахуй	120	209	8%	200	252	7%	254	316	8%	43	21%	2%	64	26%	1.8%
2.1. Амьд мал, малын мах	3	6	0%	7	12	0%	12	27	1%	6	105%	0%	15	123%	0%
2.2. Арьс, шир	106	17	1%	180	16	0%	227	12	0%	(1)	-6%	0%	(4)	-25%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	4	0%	0	4	0%	0	4	0%	(0)	-5%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	5	172	7%	6	209	6%	8	261	6%	37	22%	1%	52	25%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	6	10	0%	6	10	0%	6	11	0%	0	1%	0%	1	9%	0%
2.6. Бусад	0	1	0%	1	1	0%	1	2	0%	1	94%	0%	0	6%	0%
3. Газар тариалан	100	12	0%	102	6	0%	18	4	0%	(6)	-49%	0%	(2)	-38%	-0.1%
4. Аж үйлдвэрлэл	147	136	5%	266	166	5%	166	160	4%	30	22%	1%	(6)	-4%	-0.2%
4.1. Хүнс	3	17	1%	13	56	2%	13	37	1%	39	238%	2%	(19)	-33%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	10	0%	0	10	0%	0	13	0%	1	6%	0%	3	27%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, эдлэл	1	7	0%	1	6	0%	2	7	0%	(0)	-1%	0%	1	10%	0%
4.4. Уул уурхай	15	38	2%	20	62	2%	32	64	2%	23	61%	1%	2	3%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	1	0%	0	2	0%	(0)	-2%	0%	1	281%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	60	2%	1	27	1%	2	34	1%	(33)	-55%	-1%	7	25%	0%
4.7. Бусад	126	4	0%	231	4	0%	117	3	0%	(1)	-13%	0%	(1)	-18%	0%
5. Бусад	0	1	0%	1	0	0%	0	0	0%	(0)	-24%	0%	0	6%	0.0%
Нийт дүн		2,541		3,520			4,117			979	39%		596	17%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 7 дугаар сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	(75)		615		540	17%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(6)	-2%	294	102%	287	32%
1.2. Чулуун нүүрс	(24)	-12%	231	112%	207	15%
1.3. Боловсруулаагүй нефть	(32)	-81%	73	181%	40	19%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	38		(32)		6	4%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(83)	113%	10	-13%	(73)	-34%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	2	10%	18	90%	20	20%
1.7. Жонош, лейцит, нефелинт	25	65%	14	35%	38	94%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(2)	-30%	9	130%	7	34%
1.11. Бусад	8	130%	(2)	-30%	6	19%
2. Мал аж, ахуй	64		1		64	26%
2.1. Амьд мал, малын мах	11	74%	4	26%	15	123%
2.2. Арьс, шир	2	-64%	(6)	164%	(4)	-25%
2.3. Малын өлөн гэдэс	1	154%	(0)	-54%	0	0%
2.4. Ноолуур	50	96%	2	4%	52	25%
3. Газар тариалан	(17)		15		(2)	-38%
4. Аж үйлдвэрлэл	42		(48)		(6)	-4%
5. Бусад	(0)		0		0	6%
Нийт дүн	14		583		596	17%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2018 оны эхний 7 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 14 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 583 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ буурснаас шалтгаалж 30 сая ам.доллараар буурсан хэдий ч үнийн өсөлтөөс шалтгаалж 524 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 42 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 48 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 7 дугаар сард 1,238 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.02%-иар өссөн бол өнгөрсөн сараас 3.3%-иар буурсан байна. "А" зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,251; 65 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 4%-иар буурсан, төмрийн хүдэр 5%-иар өссөн бол өнгөрсөн сараас зэс 10.3%-иар, төмрийн хүдэр 0.7%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 7 дугаар сард 82 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 23%-иар өсч, өмнөх сараас 6.0%-иар буурсан байна.

Импорт 2018 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар буюу 929 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 19 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 6 нэгж хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		647	35%		709	30%		902	28%	61	9%	3%	193	27%	8%
Түргэн эдлэгтэй	423	334	18%	488	391	17%	550	472	14%	58	17%	3%	81	21%	3%
Хүнс	224	229	12%	214	272	12%	270	328	10%	43	19%	2%	56	21%	2%
Эм, тариа	1	50	3%	1	49	2%	2	65	2%	(1)	-1%	0%	15	31%	1%
Бусад түргэн эдлэгтэй бараа	198	55	3%	272	70	3%	279	80	2%	15	27%	1%	10	14%	0%
Удаан эдлэгтэй	79	314	17%	128	317	14%	122	430	13%	4	1%	0%	112	35%	5%
Гутал, хувцас, цүнх	32	28	2%	37	32	1%	31	39	1%	4	14%	0%	7	22%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	14	59	3%	49	48	2%	47	64	2%	(10)	-18%	-1%	16	34%	1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	191	10%	1	199	9%	1	281	9%	8	4%	0%	82	41%	4%
Бусад удаан эдлэгтэй бараа	32	36	2%	41	38	2%	43	45	1%	2	6%	0%	7	18%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	688	627	34%	652	878	38%	943	1,317	40%	252	40%	14%	439	50%	19%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	9	365	20%	14	564	24%	17	823	25%	198	54%	11%	259	46%	11%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	108	6%	1	157	7%	1	274	8%	50	46%	3%	116	74%	5%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	8	258	14%	14	406	17%	16	549	17%	148	58%	8%	143	35%	6%
Барилгын материал	447	161	9%	344	219	9%	438	374	11%	57	36%	3%	156	71%	7%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	31	100	5%	38	96	4%	24	120	4%	(4)	-4%	0%	24	25%	1%
Аж үйлдвэрлэлийн орц	525	303	17%	788	299	13%	907	438	13%	(5)	-1%	0%	139	47%	6%
Хүнсний орц	168	44	2%	24	11	0%	262	69	2%	(33)	-75%	-2%	58	514%	2%
Химийн бүтээгдэхүүн	67	46	3%	107	61	3%	119	71	2%	15	32%	1%	11	18%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	11	10	1%	23	12	1%	42	17	1%	2	24%	0%	4	34%	0%
Цахилгаан эрчим хүч	1	71	4%	1	75	3%	1	84	3%	3	5%	0%	9	12%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	1	0	0%	0	0	0%	(1)	-71%	0%	0	26%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	440	130	7%	495	140	6%	519	197	6%	9	7%	0%	57	41%	2%
Нефтийн бүтээгдэхүүн	525	252	14%	788	446	19%	907	604	18%	194	77%	11%	158	35%	7%
Дизель түлш	264	114	6%	489	255	11%	486	317	10%	142	125%	8%	62	24%	3%
АИ-92, АИ-95	182	88	5%	203	121	5%	218	132	4%	33	37%	2%	11	9%	0%
А-80 болон бусад	79	51	3%	95	70	3%	202	155	5%	20	39%	1%	85	120%	4%
Бусад	5	3	0%	9	4	0%	172	4	0%	1	52%	0%	0	5%	0%
Нийт дүн		1,833		2,337			3,266			504	28%		929	40%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	109	56%	84	44%	193	27%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	243	55%	196	45%	439	50%
Аж үйлдвэрлэлийн орц	54	39%	85	61%	139	47%
Нефтийн бүтээгдэхүүн	89	56%	69	44%	158	35%
Дизель түлш	(2)	-3%	64	103%	62	24%
АИ-92, АИ-95	9		2		11	9%
А-80 болон бусад	82		3		85	120%
Бусад	4		(4)		0	5%
Нийт дүн	499	54%	430	46%	929	40%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 439 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 193 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 158 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 139 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 929 сая ам.доллараар өссөн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 7 дугаар сард өмнөх сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 37 хувиар тус тус өсч тонн тутамд 713 ам.долларт хүрэв.